



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №35



2018 оны 10-р сарын 08-12

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1224** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 107(8.7%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1089(88.9%) хачигт халдвар, 12(1.0%) бэтэг, 2(0.2%) хумхаа, 8(0.7%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1089** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14%-иар бага байна. Эпидемиологийн 40-р долоо хоногтой харьцуулахад 2 сэжигтэй тохиолдлоор илүү байна.



Хачигт риккетсиозын 809 сэжигтэй тохиолдлын 199(24.6%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 95 сэжигтэй тохиолдлын 24(25.3%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна


1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **107** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15%-иар бага байна. Эпидемиологийн 40-р долоо хоногтой харьцуулахад 1 сэжигтэй тохиолдлоор илүү байна.



1.3 Мэрэгч амьтны дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 93 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 13.8%-иар их байна.



Энэ 7 хоногт СХД, ХУД, БГД-ээс ирүүлсэн 4 удаагийн амьтны (тарвага 8 ширхэг) дуудлагад үйлчилж, хураагдсан сорьцыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжилж байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуу өвчин:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын II багт 10 дугаар сарын 08-нд 1 өрх айлын 1 нохойд мал, амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд 10 дугаар сарын 10-ны өдрийн шинжилгээний дүнгээр галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус суманд 10 дугаар сарын 09-нд хязгаарлалтын дэглэм тогтоогоод байна. Голомтонд байгаа хүн амд үзлэг хийж, сургалт сурталчилгаа зохион байгуулж ажилласан.




Эх сурвалж: Хэнтий аймгийн ЗӨСТ, ОБЕГ

Олон улсад:

Эбола вирусүст халдвар:


БНАК улсад 10 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Kalunguta, Masereka, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвөөс нийт 162 сэжигтэй (130 батлагдсан, 32 болзошгүй) тохиолдол, үүнээс 106 нас баралт мэдээлэгдсэн байна.



Эх сурвалж: ДЭМБ

Холер өвчин:


9-р сарын 06-наас, 10-р сарын 3-ны хооронд Зимбабве улсын Харарей (хүн амын нягтшил ихтэй) хотод холер өвчний дэгдэлт бүртгэгдсэн тухай ДЭМБ-аас мэдээлжээ. Нийт 8535 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс (163 батлагдсан, 50 нас баралт). Нас баралтын түвшин 0.6%-тай байна. Ялангуяа 5-35 (56%) насны хүмүүс илүүтэй өртсөн. Харарей хотын ойролцоох мужуудаас нийт тохиолдлын 98% нь мэдээлэгдсэн. Тус хотод эрсдэлийн үеийн харилцаа холбоог эрчимжүүлэн ажиллаж байна. Зураг 1



Эх сурвалж: ДЭМБ

Мал, амьтны боом өвчин:

Украин улсын Одесса хотын Сарата мужид мал амьтны боом өвчин бүртгэгдэж, 1 үхэр өвчилсөн тул устгасан байна.



Эх сурвалж: ДЭМБ


Хэл хөхрөх өвчин:

Итали улсын Сардинияд малын хэл хөхрөх өвчний улмаас 130 хонь өртөмхий байснаас, 25 хонь өвчилсөн. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.

Эх сурвалж: ДЭМБ

Шувууны томуу өвчин:


Болгар улсын Пловдив хотын Марица мужид шувууны томуугийн H5N8 халдварын дэгдэлт бүртгэгдэж, 406 шувуу өртөмхий байснаас, 98 шувуу өвчилж үхэн, 306 шувууг устгасан байна. Тус голомтот хязгаарлалтын дэглэм тогтоож, тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажиллажээ.



Эх сурвалж: ДЭМБ

Гахайн сонгомол малзан өвчин:


Япон улсын Какамигахара хотын Гифү мужид гахайн сонгомол мялзан өвчний улмаас 1 зэрлэг гахай өвчилж үхсэн байна. Тус мужид халдваргүйтгэлийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Баруун нилийн халуурал өвчин:

Герман улсын Сачсэн-Анхалт хотын Петерсберг мужийн аж ахуйд баруун нилийн халуурал өвчний улмаас 1 адуу өвчилсөн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Энэ долоо хоногт Архангай, Баянхонгор, Өмнөговь, Хэнтий, Хөвсгөл, Ховд, Төв аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн байна. Салбар төвүүд ШУН-ийн eor@nczd.gov.mn хаяг руу мэдээгээ ирүүлж байна уу?